

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	2
2	Аудитын тайлан.....	4
2.1.	Оршил	4
2.2.	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3.	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	4
2.4.	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5.	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	5
2.6.	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7.	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8.	Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	6
2.9.	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	7
2.10.	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	7
2.12.	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	8
2.13.	Шилэн дансны мэдээлэл	8
2.14.	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	9
2.15.	Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	9
3	Менежментийн захидал	10
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	12
4.1.	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	12
4.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	13
4.3	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	15
4.4	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	17
4.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	18
4.6	Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	20
5	Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	21

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

“УЛСЫН ДУУРЬ БҮЖГИЙН
ЭРДМИЙН ТЕАТР”-ЫН
ЗАХИРАЛ Ц.ТӨВШИНТӨГС
ТАНАА

2020.02.20 № 06/544
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу “Улсын дуурь бүжгийн эрдмийн театр”-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

“Улсын дуурь бүжгийн эрдмийн театр”-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт төсвийн гүйцэтгэлийн тайлан болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар “Улсын дуурь бүжгийн эрдмийн театр”-ын 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2 Аудитын тайлан

2.1. Оршил

“Улсын дуурь бүжгийн эрдмийн театр”-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Захирал Ц.Төвшинтөгс Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг, үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөтэй холбоотой зөвлөмжийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу “Улсын дуурь бүжгийн эрдмийн театр”-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

“Улсын дуурь бүжгийн эрдмийн театр”-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 11 дүгээр сарын 12-оос 2020 оны 02 дугаар сарын 20-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 21-ний өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын захиалгаар “Грант Торнтон аудит” ХХК-ийн аудитор Г.Батхишиг, туслах аудитор Б.Эрдэнэболд нар хариуцаж хэрэгжүүлэв.

“Улсын дуурь бүжгийн эрдмийн театр”-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг “Грант Торнтон аудит” ХХК-д 2020 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр 50 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

“Улсын дуурь бүжгийн эрдмийн театр”-ын үйл ажиллагааны эрхэм зорилго нь:

“Уран бүтээлч, соёлын ажилтны мэргэжлийн ур чадварт тулгуурлан үндэсний болон сонгодог урлагийн бүтээлээр иргэдэд үйлчлэх, өөрийн сан хөмрөгт хадгалагдаж буй дэлхийн болон үндэсний сонгодог урлагийн бүтээлийг хадгалан хамгаалж, баяжуулан мэдээллийн санг бий болгон хадгалж, зохих дүрэм, журмын дагуу нийтэд түгээж, хөдөө орон нутаг, алслагдсан дүүргийн иргэдэд тогтмол үйлчилнэ.” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

“Улсын дуурь бүжгийн эрдмийн театр”-ын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Уран бүтээлч, соёлын ажилтны мэргэжлийн ур чадварт тулгуурлан үндэсний болон сонгодог урлагийн бүтээлээр иргэдэд үйлчлэх,
- Алслагдсан аймаг, дүүргийн иргэдэд тогтмол үйлчлэх,
- Соёлын арга хэмжээ, тоглолт үйлчилгээг олон түмэнд хүргэж сурталчлах менежментийг боловсронгуй болгох,
- Байгууллагын үйл ажиллагааг материаллаг орчин нөхцөлөөр сайжруулж, нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх,
- Уран бүтээлийн чанарыг өндөр түвшинд гаргаж уран бүтээлчдийн ур чадварыг дээшлүүлэх,
- Гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн тэлэх.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- 2018 оны 6 дугаар сарын 7-нд Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.6-д “Төсөв захирагчийн үйл ажиллагаа, хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээний урсгал болон хөрөнгийн зардлыг төлөвлөх, гүйцэтгэлийн хяналт хийхдээ холбогдох норм, норматив, батлагдсан стандарт, зураг төсвийг үндэслэнэ”, 24.1-д “Төсвийн зарлага нь урсгал болон хөрөнгийн зардал, эргэн төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээлийн нийлбэрээс бүрдэнэ”;
- 2019 оны 11 дүгээр сарын 13-нд Төсвийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2-д “Хуульд өөрөөр заагаагүй бол зөвхөн доор дурдсан нийгмийн үйлчилгээ үзүүлдэг төсвийн байгууллага энэ хуульд заасан журмын дагуу хандив, тусламж авч болно” гэсэн нэмэлт өөрчлөлт тус тус орсон байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцээгүй байна.

Улсын дуурь бүжгийн эрдмийн театр нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “Acolous” программ хангамж ашигладаг байна.

“Улсын дуурь бүжгийн эрдмийн театр”-ын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар “Улсын дуурь бүжгийн эрдмийн театр”-ын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 10 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар сонгов.

Материаллаг байдлын суурийг тооцохдоо нийт зардлыг суурь үзүүлэлт болгон сонгох нь зохимжтой гэж үзэв. Нийт зардлыг суурь болгосон шалтгаан нь тус байгууллага нь улсын төсвөөс санхүүждэг бөгөөд нийт зардлын 80 гаруй хувийг цалин, шагнал урамшуулал эзэлдэг тул зардлыг суурь болгосон.

Гүйцэтгэлийн үе шатанд төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлт болон хувь хэмжээг өөрчлөх шаардлагагүй гэж үзсэн бөгөөд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 4,370,359.9 мянган төгрөгийн 1 хувиар тооцон 43,703.5 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

“Улсын дуурь бүжгийн эрдмийн театр”-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 182,268.2 мянган төгрөгөөр буюу 4 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгө, засгийн газрын оролцоо данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

	/мянган төгрөг/		
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	20,003.4	-	(20,003.4)
Авлага	4,982.8	1,870.6	(3,112.2)
Бараа материал	943,783.1	1,081,610.2	137,827.1
Үндсэн хөрөнгө	3,994,319.9	3,697,340.3	(296,979.6)
Нийт хөрөнгө	4,963,089.3	4,780,821.1	(182,268.2)
Өр төлбөр	3,366.3	35.9	(3,330.4)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	4,959,723.0	4,780,785.3	(178,937.7)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	4,963,089.3	4,780,821.1	(182,268.2)

Авлага дансны үлдэгдэл буурсан нь нийгмийн даатгалын шимтгэлтэй холбоотой авлага буурсантай холбоотой байна. Авлага дансны үлдэгдэлд он удаан жил болсон авлагын үлдэгдэл байхгүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл өссөн нь бусад хангамжийн материалын үлдэгдэл өссөнөөс шалтгаалжээ. Бараа материалын дансны үлдэгдэлд тайлант онд худалдаж авсан ашиглалтгүй бараа материал байхгүй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл буурсан нь тайлант хугацаанд 363,430.0 мянган төгрөгийн элэгдлийн зардлаас шалтгаалжээ. Тайлант хугацаанд тээврийн хэрэгсэл, машин тоног төхөөрөмж, тавилга эд хогшил 64,879.0 мянган төгрөг, хандиваар болон үнэ төлбөргүй хүлээн авсан 1,571.6 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл буурсан нь харилцагч байгууллагын өглөг буурснаас шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 4,780,785.0 мянган төгрөг болж 178,938.0 мянган төгрөгөөр буурсан нь тайлант хугацаанд 178,938.0 мянган төгрөгийн алдагдалтай ажилласанаас шалтгаалжээ.

2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Нэмэлт төсөв: “Улсын дуурь бүжгийн эрдмийн театр” нь тайлант онд үндсэн үйл ажиллагаанаас 536,588.0 мянган төгрөгийн орлого олсон байна. Үүнээс: Бараа, ажил үйлчилгээний зардалд 450,443.5 мянган төгрөг, урсгал шилжүүлэг зардалд 86,144.8 мянган төгрөг тус тус зарцуулсан байна.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөрт зориулан 3,652,935 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 3,652,935.0 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулахаар батлагджээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 3,669,140.7 мянган төгрөг буюу 99,9 хувьтай байна. 2019 оны мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэлд төлбөрийн акт тогтоогдож, 6 дугаар сарын 27-нд Үндэсний аудитын газрын дансанд 20,003.4 мянган төгрөгийг тушаасан байна.

2.10. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 10 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 13 эрсдэл тодорхойлж нийт 30 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 24,384.2 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 16,912.5 мянган төгрөгийн алдааг залруулж, (дэлгэрэнгүйг 2.11-ээс харна уу) 7,471.7 мянган төгрөгийн зөрчилд 2 акт тогтоож, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

Аудитаар дараах 7,471.7 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 7,471.7 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтооллоо. Үүнд:

1. Нөхөн олговрын талаар:

- Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрээр дараах ажилчид эргэн ажилдаа орсон байна. Үүнд: Уран сайхны удирдаач Б.Түвшинбат, Эд хариуцагч нярав Г.Оюун-эрдэнэ нарт нийт 5,872.3 мянган төгрөгийн нөхөн олговор олгосон нь Захиргааны Ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1-д “Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ”, 103.2 “Энэ хуулийн 103.1-д заасан гэм буруутай албан тушаалтнаар хохирлыг төлүүлэх үүргийг тухайн захиргааны байгууллагын дээд шатны байгууллагын дотоод аудитын нэгж хариуцна”, 103.3 “Энэ хуулийн 103.2-т заасан дээд шатны байгууллагын дотоод аудитын нэгж байхгүй бол гэм буруутай албан тушаалтнаар хохирлыг

төлүүлэх үүргийг төрийн аудитын байгууллага хариуцна” заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Холбогдох хууль, эрх зүйн актын хүрээнд шийдвэрлэж ажиллах талаар акт тогтоох.

2. Нийгмийн даатгалын шимтгэлийн талаар:

- Хувь хүнтэй ажил гүйцэтгэх гэрээ хийсэн бөгөөд НДШ-ийг суутгахгүйгээр шууд ХХОАТ суутгал хийж, нийт 1,599.3 мянган төгрөгийн татвар дутуу суутгаж тайлагнасан нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 11 дүгээр зүйл 11.1.6-д *"үндсэн ажлын газраас бусад хуулийн этгээд болон хувь хүнтэй байгуулсан гэрээний үндсэн дээр ажил, үүрэг гүйцэтгэж авсан хөдөлмөрийн хөлс, шагнал, нэмэгдэл, тэтгэмж, тэдгээртэй адилтгах бусад орлого"* 17 дугаар зүйлийн 17.1.1-т *"энэ хуулийн 11.1.1, 11.1.6-д заасан орлогоос нийгмийн болон эрүүл мэндийн даатгалд төлсөн шимтгэлийг хассан дүнгээс,"* гэсэн заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Холбогдох хууль, эрх зүйн актын хүрээнд шийдвэрлэж ажиллах талаар акт тогтоох.

Аудитаар илэрсэн алдаа, зөрчилд 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.11. Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээлэл

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай холбоотой 16,912.5 мянган төгрөгийн дараах асуудлыг залруулан санхүүгийн тайланд тусгаж, "Улсын дуурь бүжгийн эрдмийн театр"-ын удирдлагаар зөвшөөрүүлэн баталгаажуулав. Үүнд:

1. Санхүүгийн байдлын тайланд НДШ-ийн авлага, өглөгийн үлдэгдлийг нэгтгэж, хаагаагүй байна. Энэ нь балансын үзүүлэлтийг 2,070.8 мянган төгрөгөөр нэмэгдүүлж харагдуулж байна.
2. "Уушгийн агуй" ХХК-д 2019 оны 08 дугаар сарын 13-ны өдөр нэмэлт санхүүжилтийн харилцах данснаас мөнгө шилжүүлж, 1,046.5 мянган төгрөгийн авлага үүсгэсэн байна. Энэ гүйлгээг бусад орлогоор бүртгэсэн бөгөөд нэр данс зөрүүтэй гүйлгээ байна.
3. Үндсэн хөрөнгө дансны тайлант онд бодогдсон хөрөнгийн элэгдлийн тооцоог давтан шалгахад 27,809.6 мянган төгрөгийн 5 нэр төрлийн хөрөнгийн элэгдэл дутуу тооцсон ба 14,482.8 мянган төгрөгийн 1 нэр төрлийн хөрөнгийн элэгдэл илүү тооцсон байна. Нийт 13,795.1 мянган төгрөгийн элэгдлийг дутуу тооцоолсон байна.

2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

- Үндсэн үйл ажиллагааны орлогыг төсөвт тусгалгүй орхигдуулсан;
- Үндсэн хөрөнгө, бараа материалын шилжилт хөдөлгөөн түүний ангиллыг үнэн зөв бүртгэж байгаа эсэх, мөн бараа материал, уран бүтээл туурвихад ашиглаж байгаа бараа материалын зарцуулалтад анхаарал хандуулах;
- Шинээр уран бүтээл туурвихад тайз декларац болон хувцас хэрэглэл чанарын шаардлага хангаж байгаа эсэх, худалдан авахад холбогдох хууль тогтоомжийг мөрдөж байгаа эсэхэд анхаарал хандуулах шаардлагатай байна.

2.13. Шилэн дансны мэдээлэл

"Улсын дуурь бүжгийн эрдмийн театр"-ын Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-6.10-д заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд батлагдсан нийт төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн мэдээллийг хугацаанд нь байршуулсан ба худалдан авалтыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, журам, босго үнэд нийцүүлэн шууд гэрээгээр хийсэн байна. Иймд Шилэн дансны тухай хуулиар хүлээсэн үүргийг хэрэгжүүлсэн байна гэж үзлээ.

2.14. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 58,562.2 мянган төгрөгийн зөрчилд 24,086.7 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоосноос 24,086.7 мянган төгрөгийг барагдуулсан, 19,700.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгах нэг албан шаардлага хүргүүлснийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

Нийт 4 зөвлөмж өгснөөс 3 зөвлөмжийг хэрэгжүүлж, 1 зөвлөмж хэрэгжих шатанд буюу зөвлөмжийн хэрэгжилт 92.7 хувьтай байна.

2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид “Улсын дуурь бүжгийн эрдмийн театр”-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн. Залруулагдаагүй 7,471.7 мянган төгрөгийн алдаа зөрчил нь бидний тогтоосон 43,703.5 мянган төгрөгийн материаллаг байдлын түвшинээс бага байгаа тул зөрчилгүй дүгнэлт өгч байна.

“Зөрчилгүй” дүгнэлт

“Улсын дуурь бүжгийн эрдмийн театр”-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйл 4.1.3 дахь заалтын дагуу үнэн зөв илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Бодлогын баримт бичигтэй холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт:

Тус байгууллага нь Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг хийлгэхээр гурван компаниас үнийн санал авч, харьцуулалтын аргаар хамгийн бага үнийн саналтай "Ди Эй Би Жи Аудит" ХХК-ийг сонгон 2020 оны 12 дугаар сарын 09-ны өдөр 9,000.0 мянган төгрөгийн үнийн дүнтэй гэрээг байгуулан урьдчилгаа 60 хувь буюу 5,940.0 мянган төгрөгийг 12 дугаар сарын 18-ны өдөр нэмэлтийн харилцах дансаар шилжүүлсэн байна.

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулна", 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Зөрчлийн тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.23-д "удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллах; Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.2-т "аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах" гэсэн заалтуудад нийцүүлж ажиллах.

3.1.2 Эрсдэл:

Хууль, журам, стандарт хэрэгжихгүй байх, хөрөнгө мөнгө шамшигдах, ашиг сонирхол үүсэх

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Батлагдсан төсвийг үр ашиггүй зарцуулахгүй, холбогдох хууль, журмыг дагаж мөрдөх,

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Зөвлөмжийн дагуу анхаарч ажиллана.

3.2 Үндсэн үйл ажиллагааны орлоготой холбоотой асуудал

3.2.1 Илрүүлэлт:

Тус байгууллага нь үндсэн үйл ажиллагааны орлогыг төсөвт тусгаагүй орхигдуулсан байна.

Сангийн сайдын 2019 оны 03 дугаар сарын 27-ний өдрийн 74 тоот тушаалын 3 дугаар зүйлийн 3.4-д “Энэ журмын 3.1.1-д үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлого бүрдүүлэх зорилгоор дараах үйл ажиллагааг хэрэгжүүлэхийг хориглоно”, 3.4.3-д “Үндсэн үйл ажиллагааны буюу байгууллагын чиг үүргийг хэрэгжүүлэх явцад бий болдог жил бүр давтагдах шинжтэй тогтмол орлогыг төсөвт тусгахгүй орхигдуулах” журмыг мөрдөж ажиллах.

3.2.2 Эрсдэл:

Хууль, журам, стандарт хэрэгжихгүй байх, хөрөнгө мөнгө шамшигдах, ашиг сонирхол үүсэх

3.2.3 Өгсөн зөвлөмж:

Байгууллагын үндсэн чиг үүрэгтэй холбоотой үйл ажиллагааны орлогыг төсөвт тусгаж байх.

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Зөвлөмжийн дагуу анхаарч ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 6 дугаар сарын 10-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	968,769,366.80	1,083,480,810.17
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	20,003,418.00	-
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	20,003,418.00	-
31213	Арилжааны банк дахь харилцах	20,003,418.00	
33	АВЛАГА	4,982,811.79	1,870,586.68
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	2,911,958.00	1,649,585.93
335	Бусад авлага	2,070,853.79	221,000.75
3351	Байгууллагаас авах авлага	2,070,853.79	221,000.75
35	БАРАА МАТЕРИАЛ	943,783,137.01	1,081,610,223.49
351	Түүхий эд материал	63,856,503.98	57,837,988.31
35110	Тусгай зориулалттай материал	5,722,854.98	5,529,888.31
35200	Дуусаагүй үйлдвэрлэл	58,133,649.00	52,308,100.00
354	Хангамжийн материал	879,926,633.03	1,023,772,235.18
35410	Бичиг хэргийн материал	709,299.00	798,845.00
35420	нормын хувцас	46,840,400.01	44,987,252.40
35430	Сэлбэг хэрэгсэл	2,257,600.00	86,000.00
35440	Түлш, шатах тослох материал	5,349,200.00	900,000.00
35470	Бусад хангамжийн материал	758,623,056.55	860,777,395.53
35600	Аж ахуйн материал	66,147,077.47	116,222,742.25
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	3,994,319,928.40	3,697,340,298.80
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,994,319,928.40	3,697,340,298.80
392	Биет хөрөнгө	3,781,640,394.49	3,486,294,098.21
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,128,338,957.19	3,128,338,957.19
39202	Хуримтлагдсан элэгдэл	-	(210,326,228.40)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	89,920,000.00	121,920,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(89,920,000.00)	(91,520,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	1,209,118,234.43	1,213,661,113.43
39206	Хуримтлагдсан элэгдэл	(726,630,269.63)	(833,513,007.59)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	226,629,941.04	236,127,983.34
39208	Хуримтлагдсан элэгдэл	(196,850,164.55)	(197,395,675.73)
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	12,715,000.00	12,715,000.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	351,149,730.00	351,149,730.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(222,831,033.99)	(244,863,774.03)
393	Биет бус хөрөнгө	212,679,533.91	211,046,200.59
39301	Програм хангамж	7,161,174.00	7,161,174.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(4,847,285.09)	(6,480,618.41)
39303	Бусад биет бус хөрөнгө	210,365,645.00	210,365,645.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	4,963,089,295.20	4,780,821,108.97
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	3,366,299.79	35,855.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	3,366,299.79	35,855.00
413	Өглөг	3,366,299.79	35,855.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	506,299.79	35,855.00
4136	Бусад өглөг	2,860,000.00	-
41361	Байгууллагад төлөх өглөг	2,860,000.00	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	4,959,722,995.41	4,780,785,253.97
51	Засгийн газрын хувь оролцоо	4,959,722,995.41	4,780,785,253.97
51101	Өмч: - төрийн	1,684,145,237.49	1,684,145,237.49
512	Хуримтлагдсан үр дүн	(590,790,977.35)	(769,728,718.80)
51210	Өмнөх үеийн үр дүн	(590,790,977.35)	(590,790,977.36)
51220	Тайлант үеийн үр дүн	-	(178,937,741.44)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	3,866,368,735.27	3,866,368,735.28
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	4,963,089,295.20	4,780,821,108.97

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,318,450,821.99	4,191,095,214.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	302,370,403.99	1,571,613.00
120	Нийтлэг татварын бус орлого	294,370,403.99	1,571,613.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	294,370,403.99	1,571,613.00
